



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2017 оны 01 сарын 11 өдөр

Дугаар 01

Ховд

Төлөвлөгөө батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-ийн “д”, 19 дүгээр зүйлийн 19.1, 20 дугаар зүйлийн 20.1.2, аймгийн ИТХ-ын 2016 оны “Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 2/03 дугаар тогтоолын 4 дүгээр зүйлийн 2 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг тус, тус үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад дэмжлэг, туслалцаа үзүүлж биелэлтийн явцад хяналт тавих ажлыг зохион байгуулан үр дүнг тооцож хагас жилээр Тэргүүлэгчдийн хуралдаанаар, бүтэн жилээр аймгийн ИТХ-ын хуралдаанаар тус тус хэлэлцүүлж ажиллахыг аймгийн ИТХ-ын дарга /Г.Пүрэвганди/-д үүрэг болгосугай.

3. Аймгийн Засаг дарга /Д.Галсандондог/-д даалгах нь:

1/. Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний заалт бүрийг тухайн жилийн үндсэн чиглэл болон ажил хариуцаж буй хэлтэс, агентлаг, сум, байгууллагуудын стратеги, жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төрийн албан хаагчдын үр дүнгийн гэрээнд тусган биелэлтийг тооцож ажиллах

2/. Хөтөлбөрийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүгийн хэрэгцээг оновчтой тооцож улсын болон орон нутгийн төсвийн төсөл, төсөөлөл, бусад

хөрөнгө оруулалтын санхүүжилтэнд тусган төлөвлөж санхүүгийн эх үүсвэрийг хангаж ажиллах

3/. Төлөвлөгөөнд тусгагдсан зарим арга хэмжээний хэрэгжилтийг хангахад гадаадын болон дотоодын хөрөнгө оруулалтыг татах, орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй хувийн хэвшил, төсөл, хөтөлбөрийн байгууллагуудаар гэрээлэн гүйцэтгүүлэх арга хэмжээ авах

4/. Хөтөлбөрийн төлөвлөгөөний биелэлтэнд хяналт үнэлгээ, шинжилгээг тухай бүр хийж хэрэгжилтийн явцыг эрчимжүүлж ажиллах

5/. Хөтөлбөрийн төлөвлөгөө болон түүний хэрэгжилтийн явцыг иргэд, олон нийтэд өргөнөөр сурталчлах ажлыг тогтмол зохион байгуулах

6/. Төлөвлөгөөний биелэлтийн дүнг хагас, бүтэн жилээр аймгийн ИТХ-ын болон Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулж ажиллах

ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2017 оны 01 сарын 11 өдөр

Дугаар 02

Ховд

Тусгай зориулалтын загас агнах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14, Амьтны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 29 дүгээр зүйлийн 29.2.3, 35 дугаар зүйлийн 35.3, Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 17.1.1, 22 дугаар зүйлийн 22.2 дахь заалтууд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2016 оны 12 дугаар сарын 02-ны А/122 дугаар тушаал, аймгийн Засаг даргын саналыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь :

1. Хар-Ус нуур орчмын Улсын тусгай хамгаалттай газар нутгийн хамгаалалтын захиргааны хяналтан доор Хар нуур, Хар-Ус нуурын загасны сүргийн бүтцийг зохицуулах зорилгоор 20000 /хорин мянга/ ширхэг загасыг агнах хуваарийг хавсралтаар баталсугай.

2. Загасны сүргийн бүтцийг зохицуулах зорилгоор агнаж буй загасны төлбөрийг килограмм тутамд 1000 төгрөг /нэг мянган/-өөр тооцож 50 хувь /тавь/-иар хөнгөлж 500 төгрөг /таван зуун/-өөр тогтоосугай.

3. Тус тогтоолоор баталсан агнах загасны тоо, хуваарь, хураах төлбөрийн хэмжээг 2017 оны 1 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлсүгэй.

4. Тогтоолын хэрэгжилтийг ханган, ажлын явцад хяналт тавьж төлбөрийн орлогыг аймгийн төсөвт төвлөрүүлэн, байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээнд зохих хууль тогтоомжийн дагуу зарцуулж ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Галсандондог/-т үүрэг болгосугай.



ДАРГА

Г.ПҮРЭВГАНДИ



Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
02 дугаар тогтоолын хавсралт

ХАР НУУР, ХАР-УС НУУРЫН ЗАГАСНЫ СҮРГИЙН БҮТЦИЙГ ЗОХИЦУУЛАХ
ЗОРИЛГООР АГНАХ ЗАГАСНЫ ТОО ХЭМЖЭЭ

| Д/д | Сумдын нэр | Агнах загасны тоо хэмжээ /ширхэгээр/ |
|-----|------------|---|
| 1. | Буянт | 7500 |
| 2. | Мянгад | 2000 |
| 3. | Дөргөн | 2000 |
| 4. | Чандмань | 7500 |
| 5. | Манхан | 1000 |
| | Бүгд | 20000 |

...oOo...



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2017 оны 01 сарын 11 өдөр

Дугаар 03

Ховд

Төлөвлөгөө батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалтыг үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн ИТХ-ын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн ИТХ-ын дарга /Г.Пүрэвганди/-д, төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлыг шуурхай зохион байгуулан үр дүнг тооцож, улирал тутам Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулж ажиллахыг аймгийн ИТХ-ын нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Сандагсүрэн/-д тус, тус үүрэг болгосугай.

ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2017 оны 01 сарын 11 өдөр

Дугаар 05

Ховд

Төлөвлөгөө батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалтыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн ИТХ-ын 2017 оны 1 дүгээр улирлын үйл ажиллагааны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулан үр дүнг тооцож Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулж ажиллахыг аймгийн ИТХ-ын нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Сандагсүрэн/-д үүрэг болгосугай.

ДАРГА  Г.ПҮРЭВГАНДИ





ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2017 оны 01 сарын 11 өдөр

Дугаар 06

Ховд

Төрийн дээд шагналаар шагнуулахаар
өргөн мэдүүлэх тухай

Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлиг, аймгийн Засаг даргын санал, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, тэмдэглэлийг үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Нийгмийн хамгааллын салбарт олон жил идэвхи зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж байгаа Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэргэжилтэн Намсрай овогтой Ойдовнямыг төрийн дээд шагнал "Алтан гадас одон"-оор шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй.

ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2017 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 07

Ховд

Тогтоол хүчингүй болгох тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.7 дахь заалтууд, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон нутгийн зөвлөл байгуулж, удирдлагаар хангаж ажиллах чиг үүрэг аймгийн Засаг даргын бүрэн эрхэд шилжсэнтэй холбогдуулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны "Салбар хорооны бүрэлдэхүүн, ажиллах дүрэм батлах тухай" 15 дугаар тогтоолыг 2017 оны 01 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

ХУРЛЫН ДАРГА -  Г.ПҮРЭВГАНДИ





ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2017 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 08

Ховд

Төлөвлөгөө батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, 20.1.14, Нийтээр тэмдэглэх баяр болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн хэмжээнд 2017 онд зохион байгуулах арга хэмжээнүүдийн нэгдсэн төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Нийтээр тэмдэглэх баяр, ойн арга хэмжээ, тэмдэглэлт өдрүүдийг салбар, байгууллагын хэмжээнд бүтээн байгуулалтын ажил өрнүүлж тэмдэглэн өнгөрүүлэх, сургалт, семинар, урлаг спорт, соёл урлагийн болон бусад арга хэмжээнүүдийг төлөвлөсөн хугацаанд нь үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг аймаг, сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавьж биелэлтийн явц, үр дүнгийн тухай аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулж ажиллахыг аймгийн ИТХ-ын Нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Сандагсүрэн/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2017 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 09

Ховд

Хөрөнгө шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, 77 дугаар зүйлийн 77.3, 80 дугаар зүйл, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 30 дугаар тогтоолын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх заалт, аймгийн Засаг даргын саналыг тус, тус үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Ховд аймгийн Орон нутгийн өмчийн газрын балансад бүртгэлтэй Land Cruiser-80 маркийн 05-05 ХОУ улсын дугаартай авто машиныг хавсралтаар Ховд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Байгууллагын хөрөнгийг хүлээлцүүлэх ажлын хэсгийг томилж, зохих журмын дагуу хүлээлцүүлэн бүртгэлээс хасахыг Ховд аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Гомбосүрэн/-д зөвшөөрч, хөрөнгө хүлээн авах комиссыг томилон бүртгэлд хүлээн авч ашиглалтыг хариуцаж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Сандагсүрэн/-д даалгасугай.

3. Хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтөд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Гомбосүрэн/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2017 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 10

Ховд

Хөрөнгө бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2, 80 дугаар зүйл, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 30 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, акталж устгах, данснаас хасах, тайлагнах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.5 дахь заалт, аймгийн Барилга байгууламжийг ашиглалтанд оруулах комиссын акт, аймгийн Засаг даргын саналыг тус, тус үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Ховд аймгийн Зэрэг сумын Гүвээ багийн эмчийн байрны засварын ажлын хавсралтад заасан 26356921 төгрөг/ хорин зургаан сая гурван зуун тавин зургаан мянга есөн зуун хорин нэгэн /-ийн хөрөнгийг сумын Эрүүл мэндийн төвийн барилгын үнийг нэмэгдүүлэн 2016 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болгон бүртгэхийг тус сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгч /М.Отгончимэг/-д зөвшөөрсүгэй.
2. Хөрөнгийг бүртгэлд тусган ашиглалтыг хариуцаж ажиллахыг Зэрэг сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгч / М.Отгончимэг /-д үүрэг болгосугай.
3. Хөрөнгийн бүртгэл, ашиглалтанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орон гүйцэтгэгч /Б.Гомбосүрэн/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА  Г.ПҮРЭВГАНДИ





ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2017 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 11

Ховд

Хөрөнгө бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2, 80 дугаар зүйл, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 30 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, акталж устгах, данснаас хасах, тайлагнах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.5 дахь заалт, аймгийн Барилга байгууламжийг ашиглалтанд оруулах комиссын актууд, аймгийн Засаг даргын саналыг тус, тус үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Ховд аймгийн Зэрэг сумын Эхэн багийн төвийн барилгын ажлын хавсралтад заасан 70000000 төгрөг /далан сая/-ийн , сумын Гүвээ багийн Соёлын төвийн байрны засварын ажлын хавсралтад заасан 30209336 төгрөг/ гучин сая хоёр зуун есөн мянга гурван зуун гучин зургаан /-ийн нийт 100209336 төгрөг /нэг зуун сая хоёр зуун есөн мянга гурван зуун гучин зургаан/-ийн хөрөнгийг Зэрэг сумын Засаг даргын Тамгын газрын балансад 2016 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болгон бүртгэхийг тус сумын Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /М.Баярт /-д зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгийг бүртгэлд тусган ашиглалтыг хариуцаж ажиллахыг Зэрэг сумын Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /М.Баярт /-д үүрэг болгосугай.

3. Хөрөнгийн бүртгэл, ашиглалтанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Гомбосүрэн/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2017 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 12

Ховд

Хөрөнгө бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 24, 77 дугаар зүйлийн 77.2, 77.3, 80 дугаар зүйл, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 30 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, акталж устгах, данснаас хасах, тайлагнах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.5 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг тус, тус үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Ховд аймгийн Жаргалант сумын 9 дүгээр цэцэрлэгт Дээрт Олон Улсын энэрэлийн байгууллагын хөрөнгө оруулалтаар хавсралтад заасан нийт 6 нэр төрлийн 5623315 төгрөг /таван сая зургаан зуун хорин гурван мянга гурван зуун арван таван/ - ийн хөрөнгийг тус цэцэрлэгийн балансад бүртгэхийг Жаргалант сумын 9 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч /Д.Отгонбаяр/-д зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгийг бүртгэлд тусган ашиглалтыг хариуцаж ажиллахыг Жаргалант сумын 9 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч /Д.Отгонбаяр/-д үүрэг болгосугай.

3. Хөрөнгийн бүртгэл, ашиглалтанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Гомбосүрэн/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017
оны...12...дүгээр тогтоолын хавсралт



**ХОВД АЙМГИЙН ЖАРГАЛАНТ СУМЫН 09-Р ЦЭЦЭРЛЭГИЙН
БАЛАНСАД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

/төгрөгөөр/

| № | Хөрөнгийн нэр | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэг бүрийн үнэ | Балансад бүртгэх үнэ | Тайлбар |
|-------------|-------------------|-------------|------------|----------------|----------------------|-----------------------------------|
| 1 | Дрож | м | 20,77 | 90000 | 1868855 | 09-Р ЦЭЦЭРЛЭГИЙН БАЛАНСАД БҮРТГЭХ |
| 2 | Угаалгын машин | ш | 1 | 960000 | 960000 | 09-Р ЦЭЦЭРЛЭГИЙН БАЛАНСАД БҮРТГЭХ |
| 3 | Угаагуур | ш | 1 | 35000 | 35000 | 09-Р ЦЭЦЭРЛЭГИЙН БАЛАНСАД БҮРТГЭХ |
| 4 | Угаагуур жижиг | ш | 3 | 45000 | 135000 | 09-Р ЦЭЦЭРЛЭГИЙН БАЛАНСАД БҮРТГЭХ |
| 5 | Хүүхдийн суултуур | ш | 7 | 117780 | 824460 | 09-Р ЦЭЦЭРЛЭГИЙН БАЛАНСАД БҮРТГЭХ |
| 6 | Дрож бор | м | 40 | 45000 | 1800000 | 09-Р ЦЭЦЭРЛЭГИЙН БАЛАНСАД БҮРТГЭХ |
| НИЙТ | | | | | 5623315 | |

...оОо...



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2017 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 13

Ховд

Хөрөнгө бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 24, 77 дугаар зүйлийн 77.2, 77.3, 80 дугаар зүйл, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 30 дугаар тогтоолоор баталсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, акталж устгах, данснаас хасах, тайлагнах журам"-ын 2 дугаар зүйлийн 2.5 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг тус, тус үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн Эрүүл мэндийн газарт хавсралтад заасан нийт 7 нэр төрлийн 76648549 төгрөг /далан зургаан сая зургаан зуун дөчин найман мянга таван зуун дөчин есөн /-ийн хөрөнгийг Эрүүл мэндийн газрын балансад бүртгэхийг аймгийн Эрүүл мэндийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Амаржаргал/-д зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгийг бүртгэлд тусган ашиглалтыг хариуцаж ажиллахыг аймгийн Эрүүл мэндийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Амаржаргал/-д үүрэг болгосугай.

3. Хөрөнгийн бүртгэл, ашиглалтанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Гомбосүрэн/-д үүрэг даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА Г.ПҮРЭВГАНДИ





Аймгийн ИТХ-Тэргүүлэгчдийн 2017 оны
13 дугаар тогтоолын хавсралт

ХОВД АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН БАЛАНСАД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

/төгрөгөөр/

| | Хөрөнгийн нэр | Ашиглалтанд орсон он | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ |
|-----------------|-------------------------|----------------------|-------------|------------|----------------|-----------------|
| 1 | Компьютер 2016 | 2016 он | ш | 32 | 1736379 | 55564128 |
| 2 | Тог баригч /UPS/ | 2016 он | ш | 32 | 400411 | 12813152 |
| 3 | Өрөөний удирдлага | 2016 он | ш | 1 | 1725893 | 1725893 |
| 4 | Төв удирдлагын үүсгэвэр | 2016 он | ш | 1 | 132838 | 132838 |
| 5 | Тог үүсгэвэр /RG-45/ | 2016 он | ш | 1 | 56930 | 56930 |
| 6 | Вирусны программ | 2016 он | ш | 4 | 1499927 | 5999708 |
| 7 | Samsung принтер | 2016 он | ш | 1 | 355900 | 355900 |
| Бүгд дүн | | | | | 5908278 | 76648549 |

...oOo...



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2017 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 14

Ховд

Нийтийн дуудлага худалдаа
зарлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 31 дүгээр зүйл 31.1, 77 дугаар зүйлийн 77.2, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 32 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг худалдах, дуудлага худалдааг зохион байгуулах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.3 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг тус, тус үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Ховд аймгийн Орон нутгийн өмчийн газрын балансад бүртгэлтэй Land Cruiser-80 маркийн 44-55 ХОА улсын дугаартай суудлын авто машины нийтийн дуудлага худалдаагаар худалдах доод үнийг хавсралтаар баталсугай.

2. Нийтийн дуудлага худалдааг 2017 оны 02 дүгээр сарын 16 өдөр аймгийн Нутгийн удирдлагын ордонд зохион байгуулсугай.

3. Нийтийн дуудлага худалдаагаар худалдах хөрөнгийн зарыг олон нийтэд ил тод мэдээлж, холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан борлуулсан орлогыг аймгийн өмчийн санд төвлөрүүлэн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтөд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Гомбосүрэн/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА Г.ПҮРЭВГАНДИ





ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2017 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 15

Ховд

Хөрөнгө шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, 77 дугаар зүйлийн 77.3, 80 дугаар зүйл, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 30 дугаар тогтоолын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх заалт, аймгийн Засаг даргын саналыг тус, тус үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Ховд аймгийн Авто тээврийн төвийн балансад бүртгэлтэй 10 нэр төрлийн 1060800 төгрөг /нэг сая жаран мянга найман зуун/-ийн үнэтэй бараа материал 1 дүгээр хавсралтаар, тус байгууллагын 2 нэр төрлийн 2184000 төгрөг /хоёр сая нэг зуун наян дөрвөн мянган/-ийн үндсэн хөрөнгийг 2 дугаар хавсралтаар тус тус аймгийн Жаргалант сумын Засаг даргын тамгын газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Байгууллагын хөрөнгийг хүлээлцүүлэх ажлын хэсгийг томилж, зохих журмын дагуу хүлээлцүүлэн бүртгэлээс хасахыг Ховд аймгийн Авто тээврийн төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Н.Ихэрзаяа /-д зөвшөөрч, хөрөнгө хүлээн авах комиссыг томилон бүртгэлд хүлээн авч ашиглалтыг хариуцаж ажиллахыг Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Т.Цагаанхишиг/-д даалгасугай.

3. Хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтөд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Гомбосүрэн/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА Г.ПҮРЭВГАНДИ




Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны
15 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

АЙМГИЙН АВТО ТЭЭВРИЙН ТӨВӨӨС ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗАРТ ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

/төгрөгөөр/

| д/д | Бараа материалын нэр | Тоо ширхэг | Нэгжийн үнэ | Дүн |
|-----|----------------------|------------|-------------|---------|
| 1 | Замын тэмдэг | 1 | 32000 | 32000 |
| 2 | Кабелийн утас | 80 | 4000 | 320000 |
| 3 | Малгай | 8 | 8000 | 64000 |
| 4 | Нормын хувцас | 8 | 35000 | 280000 |
| 5 | Пийшин | 3 | 50000 | 150000 |
| 6 | Тоолуур | 1 | 20000 | 20000 |
| 7 | Тоолуур | 1 | 30000 | 30000 |
| 8 | Тоолуур | 1 | 110800 | 110800 |
| 9 | Хантааз | 8 | 5000 | 40000 |
| 10 | Яндан | 2 | 7000 | 14000 |
| | Бүгд дүн | 113 | | 1060800 |

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн
2017 оны 15 дугаар тогтоолын
2 дугаар хавсралт



АЙМГИЙН АВТО ТЭЭВРИЙН ТӨВӨӨС ЖАРГАЛАНТ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

| д/д | Хөрөнгийн нэр | Ашиглалтанд орсон огноо | Тоо ширхэг | Балансын үнэ | Хуримтлагдсан элэгдэл |
|-----|---------------|-------------------------|------------|--------------|-----------------------|
| 1 | Барилга -1 | 2015.12.30 | 1 | 1344000 | 679881,52 |
| 2 | Барилга -2 | 2015.12.30 | 1 | 840000 | 433073,96 |
| | Нийт | | | 2184000 | 1112955,48 |

...оОо...



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2017 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 16

Ховд

Хөрөнгө ашиглалтаас хасах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, 31.3.3, 77 дугаар зүйлийн 77.2, 80 дугаар зүйл, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 30 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, акталж устгах, данснаас хасах, тайлагнах журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг тус, тус үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Ховд аймгийн Зэрэг сумын Эрүүл мэндийн төвийн балансад бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж цаашид ашиглах боломжгүй болсон хавсралтад заасан нийт 17 нэр төрлийн 25879220 төгрөг /хорин таван сая найман зуун далан есөн мянга хоёр зуун хорь/-ийн хөрөнгийг акталж данс бүртгэлээс хасахыг тус сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгч /М.Отгончимэг/-д зөвшөөрсүгэй.

2. Акталж буй хөрөнгийн ашиглаж болох хэсгийг байгууллагын өмч хамгаалах зөвлөлөөр үнэ тогтоон борлуулж байгууллагын дансад төвлөрүүлэх, бусад хөрөнгийг акт үйлдэн устгахыг Зэрэг сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгч /М.Отгончимэг/-д үүрэг болгосугай.

3. Хөрөнгийн бүртгэл, хөдлөл өөрчлөлтөнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Гомбосүрэн/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017
оны 16 дугаар тогтоолын хавсралт

ХОВД АЙМГИЙН ЗЭРЭГ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН АКТЛАЖ БҮРТГЭЛЭЭС ХАСАХ ХӨРӨНГИЙН
ЖАГСААЛТ

| № | Хөрөнгийн нэр | Ашиглалтанд орсон он | Тоо хэмжээ | Нэг бүрийн үнэ | Балансын үнэ | Хуримтлагдсан элэгдэл | Үлдэх өртөг | Тайлбар |
|---|---------------|----------------------|------------|----------------|--------------|-----------------------|-------------|---------|
|---|---------------|----------------------|------------|----------------|--------------|-----------------------|-------------|---------|

Барилга байгууламж

| | | | | | | | | |
|------|-------------|------------|---|---------|---------|---------|--------|---|
| 1 | Машины граш | 1981.12.01 | 1 | 726 180 | 726 180 | 706 008 | 20 172 | Сумын төвд засмал зам тавьж газрын албаны мэдэгдэх хуудасны дагуу буулгасан |
| Нийт | | | 1 | 726 180 | 726 180 | 706 008 | 20 172 | |

Тээврийн хэрэгсэл

| | | | | | | | | |
|------|--------------------|------------|----|-----------|------------|------------|---|-----------------------------------|
| 1 | Суудлын /мотоцикл/ | 2001.01.01 | 4 | 1 231 712 | 4 926 848 | 4 926 848 | - | Элэгдэж муудсан ашиглах боломжгүй |
| 2 | Суудлын /мотоцикл/ | 2007.01.01 | 2 | 1 424 907 | 2 849 814 | 2 849 814 | - | Элэгдэж муудсан ашиглах боломжгүй |
| 3 | Суудлын /мотоцикл/ | 2010.06.31 | 1 | 1 000 000 | 1 000 000 | 1 000 000 | - | Элэгдэж муудсан ашиглах боломжгүй |
| 4 | Суудлын /мотоцикл/ | 2010.12.31 | 2 | 1 400 000 | 2 800 000 | 2 800 000 | - | Элэгдэж муудсан ашиглах боломжгүй |
| 5 | Суудлын /мотоцикл/ | 2011.10.01 | 1 | 1 390 000 | 1 390 000 | 1 390 000 | - | Элэгдэж муудсан ашиглах боломжгүй |
| 6 | Суудлын /мотоцикл/ | 2011.10.01 | 2 | 1 260 000 | 2 520 000 | 2 520 000 | - | Элэгдэж муудсан ашиглах боломжгүй |
| 7 | Суудлын /мотоцикл/ | 2012.07.01 | 1 | 1 060 000 | 1 060 000 | 1 060 000 | - | Элэгдэж муудсан ашиглах боломжгүй |
| Нийт | | | 13 | 8 766 619 | 16 546 662 | 16 546 662 | | Элэгдэж муудсан ашиглах боломжгүй |

Тавилга эд хогшил

| | | | | | | | | |
|----------|----------------|------------|----|------------|------------|------------|--------|-----------------------------------|
| 1 | ЭКГ | 1981.01.01 | 1 | 911 817 | 911 817 | 911 817 | - | Элэгдэж муудсан ашиглах боломжгүй |
| 2 | Нарны үүсгэвэр | 1995.01.01 | 1 | 1 899 450 | 1 899 450 | 1 899 450 | - | Элэгдэж муудсан ашиглах боломжгүй |
| 3 | Хөргөгч | 1998.01.01 | 1 | 669 330 | 669 330 | 669 330 | - | Элэгдэж муудсан ашиглах боломжгүй |
| 4 | Мотор | 1998.01.01 | 1 | 940 680 | 940 680 | 940 680 | - | Элэгдэж муудсан ашиглах боломжгүй |
| 5 | Мотор | 2003.01.01 | 1 | 904 500 | 904 500 | 904 500 | - | Элэгдэж муудсан ашиглах боломжгүй |
| 6 | Компьютер | 2006.01.01 | 1 | 1 190 601 | 1 190 601 | 1 190 601 | - | Элэгдэж муудсан ашиглах боломжгүй |
| 7 | Компьютер | 2008.01.01 | 1 | 750 000 | 750 000 | 750 000 | - | Элэгдэж муудсан ашиглах боломжгүй |
| 8 | Канон принтер | 2008.01.01 | 1 | 800 000 | 800 000 | 800 000 | - | Элэгдэж муудсан ашиглах боломжгүй |
| 9 | Пульс оксометр | 2009.01.01 | 1 | 540 000 | 540 000 | 540 000 | - | Элэгдэж муудсан ашиглах боломжгүй |
| Нийт | | | 9 | 8 606 378 | 8 606 378 | 8 606 378 | - | |
| Нийт дүн | | | 23 | 18 099 177 | 25 879 220 | 25 859 048 | 20 172 | |



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2017 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 17

Ховд

Хөрөнгө ашиглалтаас хасах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1, 77 дугаар зүйлийн 77.3, 80 дугаар зүйл, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 30 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, акталж устгах, данснаас хасах, тайлагнах журам”-ын 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг тус, тус үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Ховд аймгийн Эрүүл мэндийн газрын балансад бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусч ашиглах боломжгүй болсон 9 нэр төрлийн нийт 6306122 төгрөг /зургаан сая гурван зуун зургаан мянга нэг зуун хорин хоёр/-ийн үнэтэй машин, тоног төхөөрөмжийг 1 дүгээр хавсралтад, 6 нэр төрлийн нийт 1127550 төгрөг /нэг сая нэг зуун хорин долоон мянга таван зуун тавь/-ийн үнэтэй тавилга, эд хогшлыг 2 дугаар хавсралтад, 13 нэр төрлийн нийт 890000 төгрөг /найман зуун ерөн мянга/-ийн үнэтэй бичиг хэрэг, аж ахуйн материалыг 3 дугаар хавсралтаар тус, тус акталж данс бүртгэлээс хасахыг аймгийн Эрүүл мэндийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Амаржаргал/-д зөвшөөрсүгэй.

2. Акталж буй хөрөнгийг ашиглаж болох хэсгийг байгууллагын өмч хамгаалах зөвлөлөөр үнэ тогтоон борлуулж байгууллагын дансад төвлөрүүлэх, бусад хөрөнгийг акт үйлдэн устгахыг Эрүүл мэндийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Амаржаргал/-д үүрэг болгосугай.

3. Хөрөнгийн бүртгэл, хөдлөл өөрчлөлтөнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Гомбосүрэн/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА

Г.ПҮРЭВГАНДИ



Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны
17 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ХОВД АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН АКТАЛЖ БҮРТГЭЛЭЭС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

/төгрөгөөр/

| д/д | Хөрөнгийн нэр | Ашиглалтанд орсон он | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ | Хуримтлагдсан элэгдэл | Үлдэх өртөг |
|----------|---------------|----------------------|-------------|------------|----------------|----------|-----------------------|-------------|
| 1 | Компьютер | 2007 он | ш | 1 | 1465200 | 1465200 | 1465200 | - |
| 2 | Компьютер | 2006 он | ш | 1 | 988699 | 988699 | 988699 | - |
| 3 | Компьютер | 2008 он | ш | 1 | 575000 | 575000 | 575000 | - |
| 4 | Компьютер | 2008 он | ш | 1 | 1000000 | 1000000 | 1000000 | - |
| 5 | Компьютер | 2008 он | ш | 1 | 771000 | 771000 | 771000 | - |
| 6 | Проетер | 2009 он | ш | 1 | 942423 | 942423 | 942423 | - |
| 7 | Принтер | 2009 он | ш | 1 | 159800 | 159800 | 159800 | - |
| 8 | Принтер | 2009 он | ш | 1 | 154000 | 154000 | 154000 | - |
| 9 | Принтер | 2008 он | ш | 1 | 250000 | 250000 | 250000 | - |
| Бүгд дүн | | | | | 6306122 | 6306122 | 6306122 | - |

...ооо...

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017
оны 7 дугаар тогтоолын 2 дугаар
хавсралт

АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН АКТАЛЖ БҮРТГЭЛЭЭС ХАСАХ ХӨРӨНГИЙН
ЖАГСААЛТ

| д/д | Хөрөнгийн нэр | Ашиглалтанд орсон он | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ | Хуримтлагдсан элэгдэл | Үлдэх өртөг |
|-----------------|-------------------|----------------------|-------------|------------|----------------|----------------|-----------------------|-------------|
| 1 | Хивс 2*3 | 2003 он | ш | 1 | 208035 | 208035 | 208035 | - |
| 2 | Хивс | 2003 он | ш | 1 | 25326 | 25326 | 25326 | - |
| 3 | Модон ширээ | 1997 он | ш | 5 | 1918 | 9588 | 9588 | - |
| 4 | Зөөлөвчтэй сандал | 2000 он | ш | 10 | 30753 | 307530 | 307530 | - |
| 5 | Цагаан ширээ | 2001 он | ш | 3 | 99495 | 298485 | 298485 | - |
| 6 | Шар сандал | 2001 он | ш | 7 | 39798 | 278586 | 278586 | - |
| Бүгд дүн | | | | | 405325 | 1127550 | 1127550 | - |

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны
17 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН АКТАЛЖ БҮРТГЭЛЭЭС
ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

| д/д | Хөрөнгийн нэр | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ | Хуримтлагдсан элэгдэл | Үлдэх өртөг |
|-----------------|-------------------|-------------|------------|----------------|---------------|-----------------------|-------------|
| 1 | Бичгийн хавтас | ш | 50 | 700 | 35000 | 35000 | - |
| 2 | Олон залгуур | ш | 1 | 14000 | 14000 | 14000 | - |
| 3 | Хогийн сав | ш | 3 | 20000 | 60000 | 60000 | - |
| 4 | Нормын хувцас | ш | 14 | 25000 | 350000 | 350000 | - |
| 5 | Термометр | ш | 2 | 20000 | 40000 | 40000 | - |
| 6 | Хогийн сав | ш | 3 | 20000 | 60000 | 60000 | - |
| 7 | Паялник | ш | 1 | 10000 | 10000 | 10000 | - |
| 8 | Зурагт самбар | ш | 10 | 11800 | 118000 | 118000 | - |
| 9 | Цагаан самбар | ш | 1 | 55000 | 55000 | 55000 | - |
| 10 | Залгуур | ш | 5 | 16800 | 84000 | 84000 | - |
| 11 | Уртасгагч | ш | 1 | 27000 | 27000 | 27000 | - |
| 12 | Бичиг хэргийн ком | ком | 2 | 6500 | 13000 | 13000 | - |
| 13 | Өвдгөвч | ш | 4 | 6000 | 24000 | 24000 | - |
| Бүгд дүн | | | | 232800 | 890000 | 890000 | - |



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2017 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 18

Ховд

Хөрөнгө бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 24, 77 дугаар зүйлийн 77.2, 77.3, 80 дугаар зүйл, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 30 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, акталж устгах, данснаас хасах, тайлагнах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.5 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг тус, тус үндэслэн аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Ховд аймгийн Дуут сумын Эрүүл мэндийн төвд 1 дүгээр хавсралтад заасан нийт 11 нэр төрлийн 6000000 төгрөг /зургаан сая/-ийн, сумын Хүүхдийн Цэцэрлэгт 2 дугаар хавсралтад заасан нийт 12 нэр төрлийн 10800000 төгрөг /арван сая найман зуун мянган/-ийн, сумын Ерөнхий Боловсролын сургуулийн 3 дугаар хавсралтад заасан нийт 7 нэр төрлийн 11205000 төгрөг /арван нэгэн сая хоёр зуун таван мянган/-ийн, сумын ЗДТГ-ын 4 дүгээр хавсралтад заасан нийт 11 нэр төрлийн 36850167 төгрөг /гучин зургаан сая найман зуун тавин мянга нэг зуун жаран долоо/-ийн хөрөнгүүдийг холбогдох байгууллагуудын данс бүртгэлд 2016 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болгон бүртгэхийг байгууллагын дарга, эрхлэгч нарт зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгийг бүртгэлд тусган ашиглалтыг хариуцаж ажиллахыг холбогдох байгууллагын дарга эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3. Хөрөнгийн бүртгэл, ашиглалтанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Гомбосүрэн/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017
оны...18...дугаар тогтоолын
1 дүгээр хавсралт

ХОВД АЙМГИЙН ДУУТ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН БАЛАНСАД БҮРТГЭХ
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

| № | Хөрөнгийн нэр | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэг бүрийн үнэ | Балансад бүртгэх үнэ | Тайлбар |
|-------------|--------------------|-------------|------------|----------------|----------------------|-------------------|
| 1 | Дректор | ш | 1 | 1 100 000 | 1 100 000 | Төсвийн хөрөнгөөр |
| 2 | Дэлгэц | ш | 1 | 250 000 | 250 000 | Төсвийн хөрөнгөөр |
| 3 | Люминаторийн машин | ш | 1 | 100 000 | 100 000 | Төсвийн хөрөнгөөр |
| 4 | Муляаж | ш | 1 | 450 000 | 450 000 | Төсвийн хөрөнгөөр |
| 5 | Өнгөт принтер | ш | 1 | 650 000 | 650 000 | Төсвийн хөрөнгөөр |
| 6 | Ус цэцэвшүүлэгч | ш | 1 | 110 000 | 110 000 | Төсвийн хөрөнгөөр |
| 7 | Кордорын таславч | ш | 1 | 850 000 | 850 000 | Төсвийн хөрөнгөөр |
| 8 | Сувилагчийн тех | ш | 1 | 550 000 | 550 000 | Төсвийн хөрөнгөөр |
| 9 | Хашаа | ш | 1 | 1 166 000 | 1 166 000 | Төсвийн хөрөнгөөр |
| 10 | Гэрлийн шон | ш | 1 | 280 000 | 280 000 | Төсвийн хөрөнгөөр |
| 11 | Хашааны дааман | ш | 1 | 494 000 | 494 000 | Төсвийн хөрөнгөөр |
| НИЙТ | | | | | 6 000 000 | |



Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны
12 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

ДУУТ СУМЫН ЦЭЦЭРЛЭГИЙН БАЛАНСАД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

/төгрөгөөр/

| № | Хөрөнгийн нэр | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэг бүрийн үнэ | Балансад бүртгэх үнэ |
|-------------|----------------------------------|-------------|------------|----------------|----------------------|
| 1 | Хиймэл зүлэг | м/кв | 100 | 25500 | 2550000 |
| 2 | Резинэн плита | м | 40 | 29000 | 1160000 |
| 3 | Том дүүжин даажин | ш | 2 | 254000 | 508000 |
| 4 | Жижиг дүүжин даажин | ш | 2 | 123000 | 246000 |
| 5 | Эргэдэг сандал | ш | 2 | 264500 | 529000 |
| 6 | Жаран хөлт | ш | 1 | 248000 | 248000 |
| 7 | Бөмбөгтэй танин мэдэхүйн тоглоом | ш | 1 | 262500 | 262500 |
| 8 | Савлуур | ш | 1 | 396000 | 396000 |
| 9 | Төмөр тор | м | 35 | 29420 | 1029700 |
| 10 | Сандал | ш | 18 | 3100 | 55800 |
| 11 | Сандал банз | ш | 1 | 15000 | 15000 |
| 12 | Том гулгуур | ш | 1 | 3800000 | 3800000 |
| НИЙТ | | | | | 10800000 |

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017
оны...18...дүгээр тогтоолын
3 дугаар хавсралт

ХОВД АЙМГИЙН ДУУТ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СҮРГУУЛИЙН
БАЛАНСАД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

| № | Хөрөнгийн нэр | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэг бүрийн үнэ | Балансад бүртгэх үнэ | Тайлбар |
|-------------|----------------------|-------------|------------|----------------|----------------------|-------------------|
| 1 | Сурагч ширээ цэнхэр | ш | 40 | 80 000 | 3 200 000 | Төсвийн хөрөнгөөр |
| 2 | Сурагч сандал цэнхэр | ш | 80 | 35 000 | 2 800 000 | Төсвийн хөрөнгөөр |
| 3 | Сурагч ширээ бор | ш | 12 | 120 000 | 1 440 000 | Хандиваар |
| 4 | Сурагч сандал бор | ш | 12 | 80 000 | 960 000 | Хандиваар |
| 5 | Проктер | ш | 1 | 1 425 000 | 1 425 000 | Хандиваар |
| 6 | Самбар | ш | 1 | 940 000 | 940 000 | Хандиваар |
| 7 | Самбарын хөл | ш | 1 | 440 000 | 440 000 | Хандиваар |
| НИЙТ | | | | | 11 205 000 | |

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 18 дүгээр
тогтоолын 4 дүгээр хавсралт



ДУУТ СУМЫН ЗДТГ-ЫН БАЛАНСАД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

/төгрөгөөр/

| № | Хөрөнгийн нэр | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэг бүрийн үнэ | Балансад бүртгэх үнэ |
|-------------|--------------------------------|-------------|------------|----------------|----------------------|
| 1 | Гэрэл 80 вт | ш | 38 | 250 000 | 9 500 000 |
| 2 | Гэрлийн шон | ш | 15 | 500 000 | 7 500 000 |
| 3 | Гэрлийн гар | ш | 38 | 150 000 | 5 700 000 |
| 4 | Гэрлийн кабель 4 жилтэй 10-тай | м | 800 | 8 000 | 6 400 000 |
| 5 | Сиф кабель | м | 1 100 | 5 000 | 5 500 000 |
| 6 | Кабель | м | 110 | 2 000 | 220 000 |
| 7 | Кабель 4жилтэй 25-тай | м | 5 | 10 000 | 50 000 |
| 8 | Тоолуур | ш | 1 | 270 367 | 270 367 |
| 9 | Цахилгааны шиит | ш | 1 | 310000 | 310 000 |
| 10 | Notebook Lenova | ш | 1 | 1149900 | 1 149 900 |
| 11 | Принтер самсунг | ш | 1 | 249900 | 249 900 |
| НИИТ | | | | | 36 850 167 |

...оОо...



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2017 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 19

Ховд

Хөрөнгө бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2, 77.3, 80 дугаар зүйл, аймгийн ИТХ-ын 2013 оны 30 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, акталж устгах, данснаас хасах, тайлагнах журам”-ын 2 дугаар зүйлийн 2.7 дахь заалтууд, Дэлхийн зөн олон улсын байгууллагын Ховд орон нутгийн хөгжлийн хөтөлбөрийн 2016 оны 003 тоот танилцуулга, аймгийн Засаг даргын саналыг тус, тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дэлхийн зөн олон улсын байгууллагын Ховд орон нутгийн хөгжлийн хөтөлбөрийн санхүүжилтээр хийгдсэн Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр ахлах сургуулийн 15039964 төгрөг /арван таван сая гучин есөн мянга есөн зуун жаран дөрвөн/-ийн, Хот тохижуулахын 4660275 төгрөг /дөрвөн сая зургаан зуун жаран мянга хоёр зуун далан таван/-ийн, Жаргалант сумын Ерөнхий боловсролын 7 дугаар сургуулийн 1862500 төгрөг /нэг сая найман зуун жаран хоёр мянга таван зуун/-ийн, Жаргалант сумын 6 дугаар сургуулийн 1548900 төгрөг /нэг сая таван зуун дөчин найман мянга есөн зуун/-ийн, Жаргалант сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн 17048499 төгрөг /арван долоон сая дөчин найман мянга дөрвөн зуун ерөн есөн /-ийн, Жаргалант сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2834600 төгрөг /хоёр сая найман зуун гучин дөрвөн мянга зургаан зуун/ -ийн, Рашаант багийн Өрхийн эрүүл мэндийн төвийн 1516900 төгрөг /нэг сая таван зуун арван зургаан мянга есөн зуун/-ийн, Мянгад сумын Эрүүл мэндийн төвийн 8063588 төгрөг /найман сая жаран гурван мянга таван зуун наян найман/-ийн, Дөргөн сумын цэцэрлэгийн 4901689 төгрөг /дөрвөн сая есөн зуун нэг мянга зургаан зуун наян есөн/-ийн, Жаргалант сумын 1 дүгээр цэцэрлэгийн 7178660 /долоон сая нэг зуун

далан найман мянга зургаан зуун жаран/-ийн, Жаргалант сумын 8 дугаар цэцэрлэгийн 11760513 төгрөг /арван нэгэн сая долоон зуун жаран мянга таван зуун арван гурван/-ийн, Жаргалант сумын 12 дугаар цэцэрлэгийн 4916126 төгрөг /дөрвөн сая есөн зуун арван зургаан мянга нэг зуун хорин зургаан/-ийн, Зэрэг сумын Ерөнхий боловсролын сургуулийн 12968940 төгрөг /арван хоёр сая есөн зуун жаран найман мянга есөн зуун дөчин/-ийн, Мянгад сумын Ерөнхий боловсролын сургуулийн 71006978 төгрөг /далан нэгэн сая зургаан мянга есөн зуун далан найман/-ийн, Дөргөн сумын Ерөнхий боловсролын сургуулийн 4442150 төгрөг /дөрвөн сая дөрвөн зуун дөчин хоёр мянга нэг зуун тавин/-ийн, Жаргалант сумын 5 дугаар цэцэрлэгийн 8249055 төгрөг /найман сая хоёр зуун дөчин есөн мянга тавин таван/-ийн Жаргалант сумын Ерөнхий боловсролын Цаст-Алтай цогцолбор сургуулийн 561355 төгрөг /таван зуун жаран нэгэн мянга гурван зуун тавин таван/-ийн хөрөнгүүдийг хавсралтаар тус тус баталж тухайн байгууллагуудын данс бүртгэлд бүртгэхийг холбогдох байгууллагын дарга, сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нарт зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгийг бүртгэлд тусгаж, ашиглалтанд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Гомбосүрэнд/-нд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г. ПҮРЭВГАНДИ



Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 9 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

ДЭЛХИЙН ЗӨН ОУ-ЫН БАЙГУУЛЛАГЫН ХОВД ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРӨӨС 2016 ОНД НИЙЛҮҮЛСЭН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИУДЫН БАЛАНСАД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

/төгрөгөөр/

| № | Хөрөнгийн нэр | Хэмжих нэгж | Тоо ширхэг | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ |
|--|---|-------------|------------|----------------|----------|
| Жаргалант сумын ЕБ-ийн 1 дүгээр сургууль /өсвөрийн аврагч клуб/ | | | | | |
| 1 | Өсвөрийн аврагч малгай | ш | 20 | 9108 | 182160 |
| 2 | Өсвөрийн аврагч хантааз | ш | 20 | 38412 | 768240 |
| 3 | Цагаан самбар | ш | 1 | 45455 | 45455 |
| 4 | Дамнуурга | ш | 1 | 164091 | 164091 |
| 5 | Анхны тусламжийн цүнх | ш | 1 | 345455 | 345455 |
| 6 | Проектор | ш | 1 | 1501864 | 1501864 |
| 7 | Чанга яригч | ш | 1 | 58300 | 58300 |
| 8 | Зургийн аппарат | ш | 1 | 620000 | 620000 |
| 9 | Проекторын дэлгэц | ш | 1 | 120900 | 120900 |
| 10 | Түгшүүрийн дохио | ш | 1 | 427500 | 427500 |
| 11 | Гал сөнөөгчийн иж бүрэн хувцас | ш | 1 | 550550 | 550550 |
| 12 | Шиддэг гал унтраагуур | ш | 2 | 31350 | 62700 |
| 13 | Галын аюулгүй байдлын ком/сүх.хүрз. Хадаас авагч.галын хор/ | ш | 1 | 301150 | 301150 |
| 14 | Гарцын тэмдэг,гэрэлтүүлэг | ш | 20 | 57000 | 57000 |
| 15 | компьютер | ш | 1 | 1631409 | 1631409 |
| 16 | принтер | ш | 1 | 658382 | 658382 |
| 17 | Процессор | ш | 1 | 198636 | 198636 |
| 18 | Хагас биеийн модель | ш | 1 | 697386 | 697386 |
| | Нийт | | | | 8391178 |

| Жаргалант сумын 1-р сургууль /хүүхдэд ээлтэй анги/ | | | | | |
|---|------------------------|-------------|------------|----------------|----------|
| 1 | Оффисийн сандал | ш | 1 | 173360 | 173360 |
| 2 | Оффисийн ширээ | ш | 1 | 209440 | 209440 |
| 3 | Жижиг шүүгээ | ш | 1 | 220000 | 220000 |
| 4 | МОНЕЛ ЛЕД ТВ-43 инч | ш | 1 | 544082 | 544082 |
| 5 | Аудио тоглуулагч | ш | 1 | 414454 | 414454 |
| 6 | Ус буцалгагч | ш | 1 | 150000 | 150000 |
| 7 | Сурагч ширээ сандал | ш | 25 | 163680 | 4092000 |
| 8 | Хөшиг | ш | 3 | 185150 | 555450 |
| 9 | Цэцгийн тавиур | ш | 2 | 145000 | 290000 |
| | Нийт | | | | 6648786 |
| Жаргалант сумын ЕБ-н 12 жилийн 7 дугаар сургууль | | | | | |
| 1 | Сайжруулсан 00 | ш | 1 | 1548900 | 1548900 |
| 2 | Хийл хөгжим | ш | 2 | 156800 | 313600 |
| | Нийт | ш | | | 1862500 |
| Жаргалант сумын ЕБ-н 12 жилийн 6 дугаар сургууль | | | | | |
| 1 | Сайжруулсан 00 | ш | 1 | 1548900 | 1548900 |
| | Нийт | | | | 1548900 |
| Жаргалант сумын ЕБ-ийн 12 жилийн 3-р сургууль | | | | | |
| 1 | Сайжруулсан 00 | ш | 1 | 2834600 | 2834600 |
| 2 | Морин хуур | ш | 1 | 245000 | 245000 |
| | Нийт | | | | 3079600 |
| Жаргалант сумын ЕБ-ийн 12 жилийн 2 дугаар сургууль | | | | | |
| 1 | Сайжруулсан 00 | ш | 1 | 2834600 | 2834600 |
| | Нийт | | | | 2834600 |
| Жаргалант сумын 12 жилийн 3-р сургууль /Англи хэлний кабинет/ | | | | | |
| № | Хөрөнгийн нэр | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ |
| 1 | Шилэн хаалгатай шүүгээ | ш | 1 | 707520 | 707520 |

| | | | | | |
|---|----------------------------|---|----|----------|----------|
